



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Шуурхай штаб байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, “Шинэ хоршоо” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, малчдын зээлийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, холбогдох яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор Улсын онцгой комиссын Шуурхай штабыг байгуулсугай.


2. Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, гүйцэтгэх ажлын удирдамжийг хоёрдугаар, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга (хурандаа Б.Баянмөнх)-д, шуурхай штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох яамдын сайд, агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шуурхай штабын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэх, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн үед шуурхай штабыг өргөтгөн зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга (хошууч генерал Г.Ариунбуян), Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга (хурандаа Т.Баярхүү)-д тус тус даалгасугай.


ДАРГА



С.АМАРСАЙХАН

Улсын онцгой комиссын даргын 2024 оны
10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН



Дарга:

Б.Баянмөнх–Онцгой байдлын
ерөнхий газрын Ажиллагааны
удирдлагын газрын дарга, хурандаа

Орлогч дарга:

Б.Мягмардорж– ОБЕГ-ын хэлтсийн
дарга, хурандаа

Нарийн бичиг:

Л.Баттогтох–ОБЕГ-ын Ажиллагааны
удирдлагын газрын мэргэжилтэн,
ахмад

Б.Нарандулам–Шинэ хоршоо
хөдөлгөөний салбар дундын уялдааг
хангах Үндэсний хорооны Ажлын
албаны Хамтын ажиллагаа хариуцсан
шинжээч

Б.Гантулга–ХХААХҮЯ-ны Мал аж
ахуйн бодлогын газрын ахлах
мэргэжилтэн

Гишүүд:

Ё.Азжаргал- Шинэ хоршоо
хөдөлгөөний салбар дундын уялдааг
хангах Үндэсний хорооны Ажлын
албаны дарга

Д.Баярболд–ЭМЯ-ны Нийтийн эрүүл
мэндийн газрын хэлтсийн дарга

Н.Чанцал–ОБЕГ-ын хэлтсийн дарга,
хурандаа

Т.Мөнх-Эрдэнэ–ОБЕГ-ын хэлтсийн
дарга, хошууч

С.Батзориг–БОУАӨЯ-ны Өргөдөл,
гомдол, жендер, гамшиг, дайчилгаа
хариуцсан ахлах зохион байгуулагч

П.Хишигжаргал–ГБХНХЯ-ны Ахлах
мэргэжилтэн

Ж.Дамдинсүрэн– ОБЕГ-ын тасгийн
дарга, хурандаа

Ц.Бямбацогт–ОБЕГ-ын тасгийн дарга,
хошууч

Т.Ганзориг–Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны Захиргаа хариуцсан ахлах шинжээч

Х.Сүхбаатар–Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны бодлого зохицуулалт хариуцсан ахлах шинжээч

Б.Анхбаяр– Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны сургалт, судалгаа, бүртгэл хариуцсан ахлах шинжээч

Н.Энхзул–Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн

Б.Оюунхүү–Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн

М.Өлзийсайхан–Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн

Ц.Амаржамц, ЦЕГ-ын НХЖОНАБХА-ны чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

Ш.Мөнхбулган–Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн

Б.Мөнхбат–ЭХЯ-ны мэргэжилтэн

М.Батмөнх–ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

Г.Отгончимэг–УОК-ын Ажлын албаны ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч

Б.Амаржаргал–ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, хошууч

Т.Батбаатар–ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, ахмад

Б.Отгонзаяа–ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, хошууч

Б.Бүрэнбаатар– МЭЕГ-ын ахлах мэргэжилтэн

Ж.Бундхорол–УОК-ын Ажлын албаны
мэргэжилтэн, ахмад

Б.Нэргүй–Шинэ хоршоо хөдөлгөөний
салбар дундын уялдааг хангах
Үндэсний хорооны Ажлын албаны
Санхүү хариуцсан шинжээч

Э.Болд–Шинэ хоршоо хөдөлгөөний
салбар уялдааг хангах Үндэсний
хорооны Ажлын албаны Хууль
эрхзүйн асуудал хариуцсан шинжээч

Н.Энхманлай–Шинэ хоршоо
хөдөлгөөний салбар дундын уялдааг
хангах Үндэсний хорооны Ажлын
албаны Орон нутаг хариуцсан
шинжээч

Ц.Уянга–ОБЕГ-ын мэргэжилтэн,
хошууч

М.Мөнгөнбаръяа– ОБЕГ-ын
мэргэжилтэн, хошууч

Д.Төмөрчөдөр–ОБЕГ-ын
мэргэжилтэн, хошууч

Б.Мандалбаяр–ОБЕГ-ын
мэргэжилтэн, хошууч

Т.Ууганхүү–ОБЕГ-ын мэргэжилтэн,
ахмад

Б.Цэнд–ОБЕГ-ын мэргэжилтэн, ахмад

С.Эрдэнбаяр– ОБЕГ-ын мэргэжилтэн,
ахлах дэслэгч

О.Ариунболд–ОБЕГ-ын мэргэжилтэн,
дэслэгч

С.Ренчинханд–ОБЕГ-ын мэргэжилтэн,
дэслэгч

Л.Төмөр-Ашигт малтмал, газрын
тосны газрын Газрын тосны
бүтээгдэхүүний хэлтсийн Газрын
тосны бүтээгдэхүүний нөөц, логистик
хариуцсан мэргэжилтэн

Ө.Хишигзаяа–Ус, цаг уур, орчны
судалгаа мэдээллийн хүрээлэнгийн
инженер

Ц.Одбаяр–ГСҮХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан, ахлах
дэслэгч

Н.Баярманлай–Нийслэлийн Хүнс,
хөдөө аж ахуйн газрын Газар
тариалан, мал аж ахуйн хэлтсийн

Ашигт таримал, жимс, жимсгэний
үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

Ч.Уяа-Эрдэнэ-Улаанбаатар хотын
Захирагчийн ажлын албаны Хотын
инженерийн дэд бүтцийн газрын Хот
байгуулалт, хэсэгчилсэн инженер
хангамжийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Г.Дүгэржав-ОБЕГ-ын харьяа Ар
талын 115 дугаар ангийн тооцооны
нягтлан бодогч, дэслэгч

Э.Өлзийбат-ОБЕГ-ын харьяа 115
дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

Бичиг хэргийн ажилтан:

Э.Хатантөмөр-ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын
үндэсний хүрээлэнгийн мэргэжилтэн, дэслэгч


Г.Мөнхзаяа-Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын
уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны
Төлөвлөлт, хяналт, шинжилгээ хариуцсан ахлах шинжээч

--oOo--

Улсын онцгой комиссын даргын 2024 оны
10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго



1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах, “Шинэ хоршоо” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, тулгамдсан асуудлыг Улсын онцгой комисст танилцуулан шийдвэрлүүлэх, холбогдох хүн хүч хэрэгслийг татан оролцуулах, Засгийн газар, Улсын онцгой комиссыг шуурхай мэдээ, мэдээллээр хангах.

Хоёр. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Штабын бүрэлдэхүүн 08:30-20:00 цаг хүртэл ажиллах бөгөөд 20:00 цагаас дараагийн өдрийн өглөөний 08:00 цаг хүртэл Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулах;

2.2. Шаардлагатай тохиолдолд штабын даргын шийдвэрээр Шуурхай штабыг ажлын тусгай горимоор (уртасгасан буюу 24 цагаар) ажиллуулах;

2.3. Штаб нь өвөлжилтийг хохирол багатай даван туулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах чиглэлээр гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комиссын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах;

2.4. Зудын эрсдэлийн үнэлгээ хийх, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

2.5. Үүссэн нөхцөл байдалд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөө, удирдлагын баримт бичгийг боловсруулж, тодотгох;

2.6. Хор уршгийг арилгах үйл ажиллагаанд холбогдох яам, агентлаг, аймаг, сум, нийслэл, дүүрэг, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албадын хүч хэрэгслийг татан оролцуулах, хуваарилах;

2.7. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалын судалгааг гаргах, дайчлах, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

2.8. Байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн хандив тусламжийг хүлээн авах, тараах, зохицуулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

2.9. Нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг нэгтгэн Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комисст танилцуулах;

2.10. Иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагыг өвөлжилтийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний тухай мэдээ, мэдээллээр хангах;

2.11. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.12. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч болон өвс, тэжээлийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах арга хэмжээг зохион байгуулах;

2.13. Шаардлагатай тохиолдолд шуурхай штабын гишүүдийг орон нутаг болон гамшгийн голомтод томилон ажиллуулж удирдлагаар хангуулах;

2.14. Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, алба хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн харьяалах байгууллага ажилтанд нэмэгдэл хөлс, цалин, урамшуулал, гамшгийн голомтод ажилласан томилолт олгох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.15. Малчин хоршоологчтой уулзаж, өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах чиглэлээр санал хүсэлтийг нь авах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох;

2.16. Шинэ хоршоо хөдөлгөөний хөрөнгө оруулалтын зээл авсан хоршоологчидтой уулзаж зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх;

2.17. Малчдын зээлийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

--oOo--